



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/175

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 05-ны 71 дүгээр тогтоолоор баталсан "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд урамшуулах олгох журам, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-т тусгагдсан зорилтын хүрээнд "Улсын физикийн 34 дүгээр олимпиад"-ын 9 дүгээр ангийн төрөлд 2 дугаар байр эзэлсэн Лаборатори Нэгдүгээр сургуулийн сурагч Амгаланболдын Орхонтуул, бэлтгэсэн багш Балдандоржийн Хишгээ нарыг тус бүрт 15,000,000 (арван таван сая) төгрөг, Тусгай байр эзэлсэн Лаборатори Нэгдүгээр сургуулийн сурагч Үйтүмэнгийн Цагаан-уул, бэлтгэсэн багш Базаррагчаагийн Нацагдорж нарыг тус бүр 5,000,000 (таван сая) төгрөгөөр тус тус урамшуулсугай.

2.Азийн Физикийн 23 дугаар олимпиадад оролцох эрх авсан Лаборатори Нэгдүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Бодьгэрэлийн Хувьтөгөлдөрт олимпиадад оролцох зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3.Урамшуулалд шаардагдах 42,000,000 (дөчин хоёр сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т зөвшөөрсүгэй.

4.Хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР